



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/683

Мөрөн сум

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43.1, 45 дугаар зүйлийн 45.2, 48 дугаар зүйл, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дахь зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мөрөн сумын 8 дугаар баг Титэм сургуулийн баруун талд байршилтай гэр, орон сууцны хашааны газрын зориулалттайгаар эзэмшүүлсэн 6712014910 нэгж талбарын дугаартай 500м² газрын газар эзэмшигч иргэн Намдаг овогтой Гэрэлчулуун (РЮ54092106)-ын өргөдөл, хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/520 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

2.Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/249 дүгээр захирамжийн хавсралтын 6 дахь хэсгийн Н.Гэрэлчулууны газар эзэмшсэн шийдвэрийг сэргээсүгэй.

3.Дээрх захирамжаар газрын кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулж газар эзэмшигч иргэн Намдаг овогтой Гэрэлчулуун (РЮ54092106)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4.Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Захирамж2024

6712012104